

31

Сүрьеэ (ТВ)



Сүрьеэ (ТВ) нь маш аюултай халдварт өвчин бөгөөд ихэвчлэн уушгинд тусах ба зөвхөн эмээр эмчлэгддэг. Эмгүйгээр сүрьеэ нь уушгийг удаан хугацаанд устгаж, бас үхэлд хүрэх шалтгаан болдог. Олон оронд нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд үнэгүй шинжилгээ, сүрьеэгийн эмээр хангадаг.

Хэн нэгэн сүрьеэтэй хүн ханиах, найтаалгах үед сүрьеэгийн нян агаараар дамжин тархдаг. Бусад хүмүүс, ялангуяа жижиг талбайд халдвартай хүнтэй долоо хоногоос нэг сар хүртэл хугацаанд хамт байх юм бол нянгаар нь амьсгалан халдвар авдаг. Хэт олон хүнтэй, бас агааржуулалтын тааруу системтэй үйлдвэрт, дотуур байранд, орон сууцанд сүрьеэ амархан тархдаг. Үйлдвэрүүд сүрьеэгийн талаар холбогдох журамтай байх хэрэгтэй:

- Ажлын байран дахь сүрьеэгийн асуудлыг таньж мэдэн, удирдлага болон ажиллагчдыг сүрьеэгийн талаар боловсролтой болгох, бас сүрьеэтэй ажилчдын эсрэг ялгаварлан гадуурхлыг хориглох;
- Сүрьеэгийн эмчилгээ, шинжилгээ болон ажиллагчдыг цалинтай чөлөө авч шинжилгээ өгч, бас эмчлүүлж, эдгэрч эргэн ажилдаа орохын өмнө нөхөн сэргэх боломжоор хангасан тодорхой удирдамжтай байх;

- Ажил дээр, бас дотуур байранд агааржуулалтыг сайжруулан, хэт төвлөрлийг багасган, сүрьеэгийн тархалтыг зогсоох орчин нөхцөлийн өөрчлөлт хийх.



Сүрьеэ олон хүнтэй дотуур байранд агааржуулалт муу байснаар маш хурдацтай тархдаг.

Ажил дээр сүрьеэгээс урьдчилан сэргийлэх

Үйлдвэр сайн агааржуулалтын системтэй байснаар сүрьеэгийн тархалтаас урьдчилан сэргийлэхэд тус болно. Мөн үйлдвэрийн ажилчид дотуур байранд амьдардаг бол тэнд сайн агааржуулалтын системтэй байх нь чухал юм.

Их хэмжээний тоосоор амьсгалдаг ажилчид нь сүрьеэ тусах илүү өндөр магадлалтай байдаг. Тоос нь уушгийг цочроож, сүрьеэгийн халдварын эсрэг тэмцэх чадварыг бууруулдаг. Тамхи татах нь мөн уушгийг цочроон сул дорой болгодог.

Өвчтэй эсвэл хангалттай хоол иддэггүй, сайн амардаггүй хүмүүсийн бие аль

хэдийн сул дорой болсон байдаг тул сүрьеэ тусах илүү их магадлалтай байдаг. Энэ нь ялангуяа ДОХ-той хүмүүст илүү тохиолдох ба тэд хэдийгээр сүрьеэгийн шинж тэмдэг илрээгүй байсан ч шинжилгээ хийлгэх хэрэгтэй. Сүрьеэтэй хүмүүс ч мөн ДОХ-той байж магадгүй гэж анхаарч шинжилгээ өгөх хэрэгтэй.

Үйлдвэр дээр ажилчид сүрьеэтэй байх үед орон нутгийн бусад хүмүүс ч ихэвчлэн мөн адил сүрьеэтэй байдаг. Хэрвээ үйлдвэрт хэн нэгэнд сүрьеэгийн шинж тэмдэг илрэх буюу танай орон нутагт болон гэр бүлд чинь сүрьеэтэй хүн байвал үйлдвэрчний эвлэл, орон нутгийн байгууллага, эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулагч болон эмнэлгүүд нь хамтран шинжилгээ, эмчилгээ бас урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж болно. Үйлдвэр дэх бүх хүмүүс буюу удирдлага болон ажилчдыг аль алиныг нь энэ талаар илүү их мэдлэг боловсролтой болгосноор сүрьеэгийн шинж тэмдгийг таньж, бас хаанаас эм болон дэмжлэг авах, урьдчилан сэргийлэх нь чухал гэдгийг мэдэж авна.

Сүрьеэтэй хүмүүст дэмжлэг үзүүлэх

Бүх ажилчид сүрьеэгийн эсрэг эм хэрэглэснээр үйлдвэрт бүгд илүү эрүүл болно. Зарим оронд засгийн газрын эрүүл мэндийн агентлаг нь эрүүл мэндийн ажилтнуудыг үйлдвэр рүү явуулж ажилчидтай ярилцах, шинжилгээ авах, бүх ажилчдыг эдгэртэл сүрьеэгийн эмээр хангахаар ажиллуулдаг. Олон нийтийн аюулгүй байдлын агентлаг нь ихэвчлэн сүрьеэтэй хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээ авах үнэгүй тээвэрлэлт, хүнсний дэмжлэг, өвчтэй байснаас болж алдсан цалингийн нөхөн олговор олгодог. Үйлдвэр дэх сүрьеэгийн хөтөлбөр нь орон нутгийн хөтөлбөртэй холбоотой, бүх ажилтанд нээлттэй байх ёстой.

Сүрьеэгийн эм өвчнөөс урьдчилан сэргийлж, бас эмчилнэ

Сүрьеэтэй хүн эмийг тогтмол хэрэглэж байгаа бол тэд бусдад халдаахгүй ба бие нь сайжирч эхлэх болно. Тиймээс сүрьеэтэй болсон л бол аль болох хурдан сүрьеэгийн эм ууж эхлэх нь чухал. Ихэнх оронд засгийн газрын эрүүл мэндийн үйлчилгээ нь сүрьеэгийн шинжилгээ эсвэл эмээс төлбөр нэхдэггүй. Өөр бусад олон үйл ажиллагаа нь үнэгүй шинжилгээ, эмчилгээг мөн адил санал болгодог.

Хэрвээ танд дараах өвчний шинж тэмдгийн аль нэг нь байгаа бол нэн даруй эрүүл мэндийн ажилтан дээр очиж сүрьеэгийн эм хэрэгтэй эсэхийг олж мэдэх хэрэгтэй.

Сүрьеэгийн шинж тэмдэг:

- 3 долоо хоногоос дээш хугацаагаар ханиалгах;
- Ханиалгахад гарч байгаа цэр цустай байх;
- Оройдоо бага зэрэг халуурч, хөлрөх;
- Цээж өвдөх, амьсгаа түргэсэх;
- Жин алдаж, сул дорой болох.



Нянг агаарт тархаахгүйн тулд ханиаж, найтаалгахдаа үргэлж ам, хамраа даавуугаар халхалж бай.

Сүрьеэгийн шинжилгээ

Сүрьеэгийн гурван төрлийн шинжилгээ байдаг.

- **Арьсны шинжилгээнд** бага хэмжээний шингэн таны гарын арьсан дор тарьж оруулна. Хэрвээ тухайн хүн сүрьеэтэй бол 1-3 өдрийн дотор хэсэг арьс пөмбийн гарч ирэх болно.
- **Цэрний сорил** нь эрүүл мэндийн ажилтан таныг хүчтэй ханиалгуулж, тодорхой хэмжээний цэр гаргуулж авна. Энэхүү салстын цэрэнд сүрьеэгийн нян агуулж байгаа эсэхийг лабораторид шинжлүүлнэ. Хэрвээ хоёр шинжилгээ таныг сүрьеэгийн нянтай байна гэдгийг харуулбал танд эм хэрэгтэй болно.
- Хэрвээ та сүрьеэтэй эсэх нь тодорхойгүй байвал эрүүл мэндийн ажилтан таны уушгийг рентгенээр үзэн сүрьеэ байгаа эсэхийг үзэж болно.

Сүрьеэгийн шинжилгээнүүд сөрөг гарсан ч танд сүрьеэгийн шинж тэмдгүүд байсаар байвал уушгины асуудлыг эмчлэхэд мэргэшсэн эрүүл мэндийн ажилтанд үзүүл. Та силикоз, уушгины үрэвсэл, астма эсвэл бусад төрлийн уушгины өвчтэй болсон байж болно.

Сүрьеэгийн эм

Сүрьеэгийн эм нь улс улсаасаа хамаардаг ч эмчилгээ нь хаа сайгүй дор хаяж 6 сар байдаг. Ихэвчлэн хүн 4 эм (изониазид, рифампицин, пиразинамид, этамбутол)-ийг 2 сар уугаад дараа нь ердөө 2 эм (изониазид, рифампицин)-ийг 4 сар уудаг. Таны бие дэх сүрьеэгийн нянг устгахад ийм их хэмжээний эм, ийм их хугацаа ордог байна.

Бүхий л хугацааны туршид буюу 6-12 сар ба түүнээс урт хугацаагаар тасралтгүй эм уух нь чухал юм. Хэдхэн долоо хоногийн дотор таны бие дээрдэж эхлэх ба та эдгэсэн гэж бодож болох ч эм уухыг эрт зогсоох нь маш аюултай юм. Хэрвээ бүх нянгууд нь үхээгүй бол та бусдад, гэр бүл, хамтран ажиллагчдадаа

сүрьеэгийн халдвар тараах аюултай байх ба энэ төрлийн сүрьеэгээр өвдсөн хүмүүсийг эмчлэх нь маш хэцүү байдаг. Үүнийг MDR (олон эмийн дасалтай) сүрьеэ гэдэг.

Хэрвээ та сүрьеэгийн эм ууж байгаа ч сайжирч өгөхгүй байвал та магадгүй олон эмийн дасалтай сүрьеэтэй байж болох ба танд эмчлүүлэхийн тулд өөр төрлийн эм хэрэгтэй. Эрүүл мэндийн ажилтанд үзүүл.

Сүрьеэгийн эсрэг эм ууж байгаа хүн илүү дээрдэж эхэлсний дараа түүний гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагчид нь түүнийг бүх сарынхаа эмчилгээг даван туулахад дэмжлэг үзүүлэх нь чухал юм. Түүнд сүрьеэгийн эмээ өдөр бүр уухыг нь сануулж, тусалж бай.

